

## АГУУЛГА

	Хуудасны дугаар
1. ЗДТГ /САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС/	2
2. СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС	3
3. ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГДЭЛ	7
4. НЭГДСЭН ЭМНЭЛЭГ	9
5. ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТЭС	10
6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС	12
7. ЦАГДААГИЙН ХЭЛТЭС	13

## ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

### Санхүү, төрийн сангийн хэлтэс

Оны эхний 01 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогыг 4570.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс 4.47 хувиар буюу 204.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орон нутгийн төсвийн зарлага 915.5 сая төгрөг болсон байна.

Орон нутгийн төсвийн орлогын 11.53 хувь буюу 4775.3 сая төгрөгийг татварын орлогоор, 88.47 хувийг татварын бус орлогоор тус тус бүрдүүлсэн байна. Нийт татварын орлого 48.88 хувь нь орлогын албан татвараас, 0.23 хувь нь хөрөнгийн албан татвараас, 50.88 хувь нь бусад татвар / төлбөр хураамж/ -аас тус тус бүрдсэн байна.


Бусад татвар / төлбөр хураамж/-ын 21.50 хувийг буюу 60.2 сая төгрөгийг Улсын тэмдэгтийн хураамжаас, 76.89 хувийг буюу 215.4 сая төгрөгийг Хог хаягдал үйлчилгээний хураамжаас тус тус бүрдүүлсэн байна.

Хүснэгт 1. Орон нутгийн төсвийн орлого, зарлага / мян төгрөгөөр/

	2015.01	
	Төлөв	Гүйцэт
Нийт орлого ба тусламжийн дүн	4570865.1	4775254.5
А.Урсгал орлого	4570865.1	4775254.5
1. Татварын орлого	407833.0	550669.3
2. Татварийн бус орлого	4163032.1	4224585.2
Б. Хөрөнгийн орлого	0.0	0.0
Улсын болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	4015569.5	4166624.4
1. Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	4015569.5	3732804.8
Нийт зарлагын дүн	992989.6	915493.5
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	300401.6	266733.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33005.8	30817.9
Бараа, үйлчилгээний бусад зардал	659582.2	617942.5

Орон нутгийн төсвийн зарлагын 29.14 хувийг Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардалд зарцуулсан бөгөөд нийт цалин, хөлс нэмэгдэл урамшууллын зардлын 71.01 хувийг цалин хөлс, 14.65 хувийг нэмэгдэл, урамшуулалд, 11.96 хувийг унаа, хоолны хөнгөлтөнд тус тус зарцуулсан байна. Харин бараа үйлчилгээний бусад зардалд 617.9 сая төгрөг буюу 67.50 хувийг тус тус зарцуулсан байна.

Зураг -1 Төсвийн урсгал зардлыг төрлөөр






## СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

### 1. Хэрэглээний үнэ

Өрхийн хэрэглээнд гол үүрэг гүйцэтгэдэг өргөн хэрэглээний барааны нэг болох түлшний үнэ Хангай захад 2015 оны 01-р сарын 28-ний өдрийн байдлаар нэг шуудай хар 1000 төгрөг, нарс мод 900 төгрөгийн үнэтэй байлаа.


Дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг ШТС-уудын дундаж үнийг харвал: 2015 оны 01 сарын 28-ний өдрийн байдлаар АИ-92 шатахуун 1660 төгрөг, АИ-80 шатахуун 1550 төгрөг дизель түлш 1790 төгрөгийн үнэтэй байна

Зураг -2 Шатахууны үнэ 01-р сарын 28-ны байдлаар, төгрөгөөр




Өргөн хэрэглээний хүнсний барааны нэг болох махны үнийг зарим дэлгүүрүүдээр харвал хонины ястай мах 1 кг нь Миний зах дэлгүүр, Хар хорин захад 5500 төгрөгийн үнэтэй байна. Харин үхрийн цул мах 1 кг нь Миний зах дэлгүүр 9300 төгрөг байхад Хар хорин зах дээр 8000 төгрөгийн үнэтэй байлаа.

Зураг -3. Нэг кг үхрийн махны дундаж үнэ, төгрөг, 2007-2014 оны 01-р сард




Миний зах, Макс супер маркет, Хар хорин захуудын "Алтан тариа" ХК-ны дээд зэргийн гурлын үнийг харьцуулбал 1 кг дээд гурилын үнэ Хар хорин зах, Хангалуун трейд ХХК, БОСА дэлгүүрүүдэд 1200 төгрөг, Миний зах дэлгүүрт 1280 төгрөг, Гүнгэрваа захад 1300 төгрөгийн үнэтэй байна.

Зураг- 4. Алтан тариа ХХК –ны дээдийн дээд гурлын 1кг-ын үнэ, 2015 оны 01-р сарын байдлаар



Зураг- 5. Хүнсний ногооны дундаж үнэ, 2015 оны 01-р сарын байдлаар



Миний зах, Макс супер маркет, Хар хорин захуудын төмс, хүнсний ногооны үнийг харьцуулбал 1 кг төмсний үнэ Хар хорин зах, Миний зах дэлгүүрт 1000 төгрөг байна. Макс супер маркет, Хангалуун трейд ХХК дэлгүүрүүдэд 1 кг луувангийн үнэ тус бүр 1200 төгрөг байхад Гүнгэрваа захад 1000 төгрөгийн үнэтэй байна. Харин 1 кг байцааны үнэ Хар хорин зах дээр 1100 төгрөг, Миний дэлгүүрт 900 төгрөг, Макс супер маркетэд 1000 төгрөгийн үнэтэй байна.

Зураг -6. Нэг кг лууван, төмсний үнэ, төгрөгөөр, 2007-2014 оны 11-р сарын байдлаар



Хүснэгт 2. Хэрэглээний үнэ, дүүргийн зарим хүнсний дэлгүүрээр 01-р сарын 28 ны байдлаар

	Миний зах Саппоро	Мах супермаркет	Хангалуун трейд ХХК	хар хорин зах	Гүнгэрваа	БОСА	ДҮҮХЭЭ2	Дундаж үнэ
Гурил, дээдийн дээд зэрэг, "Алтан тариа" ХК, савласан / улбар шар/	1500	1700	1600	1550		1560		1,582
Гурил, дээд зэрэг, "Алтан тариа" ХК, савласан /улаан/	1280	1250	1200	1200	1300	1200	1100	1,219
Гурил, 2-р зэрэг, "Алтан тариа" ХК, савласан /ногоон/		910	850	750	800	800	730	807
Гоймон, дотоод, Алтан тариа, /улбар шар/	780	780	780	700	760	700	700	743
Цагаан будаа, кг, задгай	2400	2400	2200	2200	2300	2300	2000	2,257
Хонины ястай мах, кг	5500	6400		5500	5500		5000	5,580
Үхрийн ястай мах, кг	7500	7400		7000	7500		6500	7,180
Үхрийн гуяны цул мах, кг	9300	8300		8000	8500			8,525
Адууны ястай мах, кг				5000	5500			5,250
Ямааны ястай мах, кг				5000	5300			5,150
Хиам, хагас утлагатай, "Сальям", "Траст Трейд" ХК	7330	7350	7500	6800	6800	7300	7000	7,154
Сүү, задгай, литр	1700			1500	1700			1,633
Сүү, савласан, "Элекстер", 500 гр	1100	1100	1200	1100	1100	1100	1050	1,107
Сүү, хайрцагтай, 1л, "Шинэ Сүү", "Сүү" ХК	2450	2450	2500	2400	2500	2300	2400	2,429
Цэцгийн тос, 200 гр, "Сүү"ХК	2600	2500	2500	2400	2400	2500	2500	2,486
Өндөг	350	350	350	300	380	300	300	333
Төмс, Монгол, кг	1000	1200	1000	1000	1000	800	800	971
Лууван, дотоод, кг	950	1200	1200	1500	1300	1000	1000	1,164
Манжин, дотоод, кг	1600	1500	1500	2000		1500	1500	1,600
Байцаа, Хятад, кг	900	1000	1100	1100	1200	1000	1000	1,043
Сонгино, Хятад, кг	1200	1200	1500	1000	1200	1200	1100	1,200
Алим, "Фүжи" хятад, кг	4900	4900	4500	4000	4500	4000	4000	4,400
Элсэн чихэр, кг, орос	1900	1900	1900	1800	1800	1900	1600	1,829
Ёотон, орос, 500гр	1800	1700	1700	1700	1700	1500	1600	1,671
Хатуу чихэр, "Барбарис", орос, 1 кг	4400	4000	4500	4000	4800	4500	4500	4,386
Шоколад, "Alpen Gold"	1900	1800	1900	1700	1700	1700	1700	1,771
Давс, цагаан, 1 кг, йоджуулсан	700	550	600	500	500	500	550	557
Ногоон цай, савласан, Гүрж			7500	7000	7500			7,333
Байхуу цай, Липтон, 20 ширхэгтэй	2500	2500	2500	2300	2500	2300	2300	2,414
Кофе, "Nescafe", Классик, 100 гр	7800	7400	7630	7400		7800	7400	7,572
Цагаан архи, "Ерөөл", 0.5л, "АПУ" ХК	1350	1250	1200	1300		1200	1250	1,258
Пиво, "Боргио", 0.5 л, "АПУ" ХК	1500	1700	1600	1550		1560		1,582

## 2. Хүн ам, өрхийн мэдээллий сан

### Хүснэгт 3. Хүн ам, өрхийн мэдээлэлийн сангийн бүрдэлт

Хороо	2014 жилийн эцсийн хүн амын тоо	ХАӨМС-д байгаа хүн амын тоо	ХАӨМС-д байгаа өрхийн тоо	Шилжилт баталгаажуулах хүний тоо	Шилжилт хүлээгдэж буй хүний тоо	Шилжилт баталгаажуулах өрхийн тоо	Шилжилт хүлээгдэж буй өрхийн тоо	Нийт оруулах ёстой	Оруулсан	Оруулаагүй
1-р хороо	13 063	12 749	3 760	25	50	23	20	2 147	368	1 779
2-р хороо	10 327	12 923	4 029	0	45	2	10	1 905	1 414	491
3-р хороо	8 080	9 375	2 383	114	109	19	3	2 146	902	1 244
4-р хороо	15 786	7 924	2 052	30	162	24	0	1 430	1 324	106
5-р хороо	8 712	7 927	1 907	154	84	5	2	2 299	1 879	420
6-р хороо	9 243	9 992	2 779	1	6	8	0	1 498	1 347	151
7-р хороо	5 227	16 482	5 051	210	142	8	0	4 777	3 197	1 580
8-р хороо	5 371	8 374	2 150	86	40	13	2	1 619	1 072	547
9-р хороо	5 082	8 910	2 240	22	18	14	0	1 525	1 231	294
10-р хороо	5 090	10 145	2 390	261	103	11	1	2 128	1 733	395
11-р хороо	7 285	10 045	2 319	45	19	18	0	889	875	14
12-р хороо	9 778	5 056	1 286	9	9	15	0	297	286	11
13-р хороо	6 527	5 384	1 374	154	14	12	0	691	332	359
14-р хороо	6 311	5 546	1 397	71	7	14	0	758	544	214
15-р хороо	15 587	6 052	1 407	0	2	13	2	778	695	83
16-р хороо	13 075	5 445	1 425	16	11	20	0	535	525	10
17-р хороо	11 243	5 076	1 193	0	1	7	0	752	591	161
18-р хороо	11 954	7 118	2 131	13	29	15	0	1 445	1 038	407
19-р хороо	14 928	8 315	2 218	52	31	17	36	1 444	828	616
20-р хороо	5 409	7 048	1 815	14	19	19	24	812	811	1
21-р хороо	6 631	5 122	1 898	52	12	7	0	1 137	1 027	110
22-р хороо	6 007	13 192	4 672	294	127	20	109	5 417	4 313	1 104
23-р хороо	6 263	13 426	3 379	145	44	31	3	2 684	2 645	39
24-р хороо	11 138	11 368	3 533	26	49	16	13	1 456	1 389	67
25-р хороо	2 977	12 014	3 331	2	105	15	8	1 849	1 213	636
26-р хороо	12 199	13 260	4 208	356	246	13	0	2 789	1 577	1 212
27-р хороо	7 655	5 529	1 751	1	12	19	0	1 298	649	649
28-р хороо	7 373	5 952	1 781	54	18	4	0	1 250	999	251
29-р хороо	9 090	6 352	1 998	119	3	9	0	862	556	306
30-р хороо	9 691	6 534	1 448	51	70	5	4	454	453	1
31-р хороо	4 952	10 606	2 858	3	217	12	0	4 034	3 999	35
32-р хороо	5 258	2 481	911	4	5	6	3	843	340	503
Дүн	277 312	275 722	77 074	2 384	1 809	434	240	53 948	40 152	13 796

Хүн ам өрхийн мэдээллийн санд 2015 оны 2-р сарын 17-ний өдрийн байдлаар нийт 275722 хүний мэдээлэл орсон байна. Хороодын ажлын явцыг харвал 20-р хороо, 30-р хороо хүн амын мэдээлэлээ бүрэн оруулсан бөгөөд 1-р хороо, 3-р хороо, 7-р хороо, 22-р хороо, 26-р хороодын ажлын явц удаашралтай байна



## ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГДЭЛ

### Эрүүл мэндийн үйлчилгээ

Оны эхний 01 сарын байдлаар дүүргийн хэмжээнд 641 эхээс 650 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 24-өөр бага байна. Он гарсаар 0-1 насны хүүхдийн эндэгдэл 12 гарсан нь өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өссөн байна. Харин 1-5 настай хүүхдийн эндэгдэл 2 гарсан нь өмнөх оны мөн үеэс 33.33 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд эхийн эндэгдэл гараагүй байна.

Хүснэгт 4. Төрөлт, нас баралтын үзүүлэлт, харьцуулсан оноор

Үзүүлэлтүүд	2014-01 сар		2015-01 сар	
	Бодит тоо	1000 хүн амд	Бодит тоо	1000 хүн амд
Төрсөн эх	665		641	
Амьд төрсөн нярай	670		650	
Нийт нас баралт	127		112	
0-1 насны хүүхдийн эндэгдэл	5	7.46	12	18.46
1-5 насны хүүхдийн эндэгдэл	3	4.48	2	3.08
Эхийн эндэгдэл	0	0.00	0	0

Тайлант хугацаанд 0-1 настай хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 18.46 промилл ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 11.00 промиллиор өссөн бол 1-5 настай хүүхдийн эндэгдэл тайлант хугацаанд 3.08 промилл байгаа нь өмнөх оноос 1.40 промиллиор буурсан байна.

Зураг-7. Төрөлт, харьцуулсан оноор



Тайлант хугацаанд халдварт өвчнөөр өвчлөгсөд 249 бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад халдварт өвчний гаралт 42.23 хувиар буюу 74 тохиолдлоор өссөн байна.

2014 оны 01-р сард 10000 хүнд ногдох халдварт өвчин 6.00 промилл байсан бол 2015 онд 9.00 промилл болж 3.00 промиллээр өсжээ.

Халдварт өвчний гаралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулан харвал гахайн хавдар 2 тохиолдлоор, ГХА 5 тохиолдлоор тус тус буурсан байна. Харин заг хүйтэн 14 тохиолдлоор, салхин цэцэг 21 тохиолдлоор, тэмбүү 26 тохиолдлоор, цусан суулга


1 тохиолдлоор, сүрьеэ 2 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна. Халдварт өвчний хамгийн их бүртгэгдсэн нь тэмбүү өвчин ба тайлант хугацаанд 71 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 57.78 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд тэмбүү өвчин нийслэлд 268 тохиолдол бүртгэгдсэний 26.49 хувь нь тус дүүргийнх, салхин цэцэг 380 тохиолдол бүртгэгдсэний 58 нь буюу 15.26 хувь нь тус дүүргийнх байна.

Хүснэгт 5. Халдварт өвчний гаралт, төрлөөр, өмнөх онтой харьцуулснаар

	2013 он		2014 он		УБ хот	
	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд	Бодит тоо	10000 хүн амд
<b>Бүгд халдварт өвчин</b>	<b>175</b>	<b>6</b>	<b>249</b>	<b>9</b>	<b>1282</b>	<b>9.93</b>
<b>Бүгд цочмог халдварт өвчин</b>	<b>70</b>	<b>2.60</b>	<b>87</b>	<b>3.23</b>	<b>576</b>	<b>4.62</b>
Цусан суулга	12	0.45	13	0.45	79	0.61
Улаан эсэргэнэ	1	0.04	1	0.03	18	0.14
Менингит	0	0	0	0	0	0
Гепатит	7	0.26	7	0.24	46	0.36
Салхинцэцэг	37	1.37	58	2.02	380	2.94
Гахайн хавдар	3	0.11	1	0.03	7	0.05
Сальмонеллэз	0	0	2	0.07	5	0.04
Бруцеллэз	0	0	0	0	0	0
Ёлом	2	0.07	2	0.07	8	0.06
ГХА өвчин	8	0.3	3	0.1	32	0.25
Улаанууд	0	0	0	0	0	0
Хоолны хордлого	0	0	0	0	0	0
Тэмбүү	45	1.67	71	2.48	268	2.08
Заг хүйтэн	8	0.3	22	0.77	77	0.6
Шинэ илэрсэн сүрьеэ	34	1.26	36	1.26	214	1.66
Мөөгөнцөр	0	0	0.00	0	23	0.18
Трихомониаз	18	0.67	33	1.15	124	0.96

Тайлант хугацаанд дүүргийн эмнэлэгийн байгууллагууд 136488 үзлэг хийсний 37.41 хувь нь урьдчилан сэргийлэх, 18.30 хувь нь гэрийн үзлэг байна. Дүүргийн эмнэлэгийн орны тоо 380 бөгөөд тайлант хугацаанд 11701 ор хоног ашигласан байна. Халдварт бус өвчлөл 32087 гарсан байна.

Зураг- 8 Халдварт өвчний гаралт оноор, төрлөөр







## НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

### Эрүүл мэндийн үйлчилгээ

Оны эхний 01 сарын байдлаар 842 эх шинээр хяналтанд орсон ба нийт жирэмсэн эхчүүд 97.98 хувь цусны ерөнхий шинжилгээнд хамрагдсанаас 4.97 хувь нь цус багадалттай, 3.03 хувьд нь трихомониаз, 1.33 хувьд нь заг хүйтэн, 4.24 хувьд нь тэмбүүгийн өвчлөл илэрсэн байна. Шинээр хяналтанд орсон жирэмсэн эхчүүдийн 87.53 хувь нь жирэмсэний эхний 3 сартайдаа хяналтанд орсон байна.

#### Хүснэгт 6. Жирэмсний хяналттай холбоотой үзүүлэлтүүд

Үзүүлэлт			Тоо
Жирэмсний хяналт	Жирэмсний хяналтад байгаа эмэгтэйчүүдийн тоо		4510
	Жирэмсний хяналтанд шинээр авсан эмэгтэйчүүдийн тоо		842
	Үүнээс	Эхний 3 сартайд	737
		4-6 сартайд	98
		7 ба түүнээс дээш сартайд	7
	Жирэмсний хяналтад шинээр авсан эмэгтэйчүүд цусны шинжилгээнд хамрагдсан тоо		825
Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо		41	
Шинээр хяналтанд хамрагдсан жирэмсэний эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээ	Трихомониаз илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо		825
	Үүнээс: эерэг		25
	Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо		825
	Үүнээс: эерэг		11
	Тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо		825
	Үүнээс: эерэг		35
	ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд хамрагдсан хүний тоо		825
	Үүнээс: эерэг		0

Эхний 01 сарын байдлаар артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих хүн амын 3.21 хувь нь буюу 2081 хүн хамрагдсан байна. Үүнээс 53.34 хувь нь давтан үзлэгт хамрагдсан байна. Чихрийн шижин хэв шинж 2 - ын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих хүн амын 2.25 хувь нь буюу 1459 хүн хамрагдсаны 59.49 хувь нь эмэгтэйчүүд хамрагдсан байна.

#### Хүснэгт 7. Халдварт бус өвчний эрт илрүүлэлтийн үзлэгийн тоо

Үзүүлэлт		Тоо
Хамрагдах хүн амын тоо		64863
Амбулторын үзлэг	Артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо	2081
	Хамрагдалт ын хувь	3.21
	Эрэгтэй	854
	Эмэгтэй	1227
	Давтан үзлэг	1110
	Оношлогдсон артерийн гипертензи	247
	Чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт анх удаа хамрагдсан хүний тоо	1459
	Хамрагдалт ын хувь	2.25
	Эрэгтэй	591
	Эмэгтэй	868
	Давтан үзлэг	846
	Оношлогдсон чихрийн шижин	46

## ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТЭС

### Ажил хайгч иргэн


Оны эхний 01 сарын байдлаар ажил хайгч иргэдийн тоо 1699 болсон байна. Үүнээс 20 нь буюу 1.18 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Ажил хайгч иргэдийг боловсролын түвшингээр нь ангилж үзэхэд дипломын болон бакалаврын дээд боловсролтой 690 хүн буюу 40.61 хувь, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 126 хүн буюу 7.42 хувь, техникийн болон мэргэжлийн боловсролтой 117 хүн буюу 6.88 хувь, бүрэн дунд боловсролтой 674 хүн буюу 39.67 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 8. Ажил хайгч иргэний тоо, боловсролын түвшин, насны бүлгээр

Ажил хайгч иргэн /сарын эцэст/	Боловсролын түвшнээр							
	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр, доктор
1699	2	16	46	674	117	126	690	28
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Насны бүлгээр						
		15-24	25-34	35-44	45-54	55-59	60+	
	20	453	678	324	194	39	11	

Нийт бүртгүүлсэн ажил хайгч иргэний 882 буюу 51.91 хувь нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд бүртгэлтэй ажил хайгч иргэнээс 84 хүн ажилд зуучлагдан орсон байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдээс ажилд зуучлагдан орсон иргэдийг насны бүлгээр харвал 15-24 насны залуучууд 42.86 хувь, 25-34 насныхан 30.95 хувь, 35-44 насныхан 10.71 хувь, 45-54 насныхан 14.29 хувь, 55-59 насныхан 1.19 хувийг тус тус эзэлж байна.

Зураг -9. Ажилд зуучлагдан орсон иргэд, боловсролын түвшингээр, хувиар



Ажилд зуучлагдан орсон иргэдийг боловсролын түвшингээр харвал дээд боловсролтой 30.95 хувь, тусгай дунд боловсролтой 2.38 хувь, техник мэргэжлийн боловсролтой 7.14 хувь, бүрэн дунд боловсролтой 55.95 хувь, бүрэн бус дунд боловсролтой 1.19 хувь хувийг тус тус эзэлж нь байна.

2015 оны нэгдүгээр сарын байдлаар бүртгэлтэй ажил хайгч иргэний тоо 418-аар нэмэгдэж, 916 хүн бүртгэлээс хасагдсан байна.

Хүснэгт 9. Ажил хайгч иргэний тоо 2015 оны 01-р сарын байдлаар

Үзүүлэлтүүд		Бүгд
Ажил хайгч иргэн /сарын эхэнд/		2197
Үүнээс: Эмэгтэй		1195
Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн		418
Үүнээс: Эмэгтэй		185
Ажил хайж байгаа шалтгаанаар	Шилжин суурьшсан	51
	Сургуулиа орхисон /гарсан, чөлөө авсан/	8
	Сургууль төгсөөд ажилгүй байгаа	105
	Гадаадаас эргэж ирсэн	12
Ажлаас чөлөөлөгдсөн/ халагдсан	Мэргэжил, ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх	0
	Тэтгэвэрт гарсан	4
	Орон тооны цомхотголд орсон	116
	Байгууллага татан буугдсан	26
	Бусад	78
Тайлант хугацаанд хасагдсан		916
Ажилд зуучлагдан орсон		84
Байгууллагын хариуцлагын хэлбэрээр	Хувьцаат компани	0
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	72
	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	0
	Төрийн өмчим аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	0
	Төрийн бус байгууллага	2
	Хоршоо	0
	Төсөвт байгууллага	10
Насны бүлгээр	15 - 24	36
	25 - 34	26
	35 - 44	9
	45-54	12
	55-59	1
	60+	0
Боловсролын түвшингээр	Магистр, доктор	1
	Дипломын болон бакалаврын	26
	Тусгай мэргэжлийн дунд	2
	Техникийн болон мэргэжлийн	6
	Бүрэн дунд	47
	Суурь	1
	Бага	0
	Боловсролгүй	1
Ажил хайгч иргэн /сарын эцэст/		1699
Үүнээс: Эмэгтэй		882



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

Нийгмийн даатгалын үйлчилгээ

Оны эхний 01 сарын байдлаар нийгмийн даатгалд 1698 аж ахуй нэгж, байгууллагын 26687 хүн, 104 төсөвт байгууллагын 6253 хүн тус тус даатгалд хамрагдсан байна. Сайн дурын даатгалд 5171 хүн хамрагджээ.

Нэгдүгээр сарын байдлаар нийт 30190 хүн 8197.1 сая төгрөгийн тэтгэвэр авсан байна. Үүний 72.05 хувь нь буюу 21396 хүн өндөр настны тэтгэвэр, 9.79 хувь нь буюу 4110 хүн тахир дутуугийн тэтгэвэр, 3.57 хувь нь буюу 1528 тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 3.99 хувь нь буюу 3156 хүн цэргийн тэтгэвэр тус тус авсан байна.

Тэтгэмжийн даатгалын санд нийт 797 хүнд 312.8 сая төгрөгийн тэтгэмж зарцуулсан байна. Үүнд: хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжинд 34.5 сая төгрөг, жирэмсэн ба амаржсаны тэтгэмжинд 274.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалд нийт 501 хүнд 176.5 сая төгрөг зарцуулсанаас тахир дутуугийн тэтгэвэрт 155.4 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 17.7 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Хүснэгт 10. Нийгмийн даатгалд даатгуулагчдийн тоо, зарцуулалт /сая төгрөгөөр, 2015.01 сар/

Үзүүлэлт	Хүний тоо	Дүн сая, төгрөг
1) Шимтгэл төлөгч байгууллагын тоо/ Аж ахуй нэгж байгууллага /	1698	-
а. Даатгуулагчийн тоо	26687	-
б. Цалингийн сан	12360.8	-
2) Шимтгэл төлөгч байгууллагын тоо/ Төсөвт байгууллага /	104	-
а. Даатгуулагчийн тоо	6253	-
б. Цалингийн сан	5813.4	-
3) Сайн дурын даатгал	5171	-
4) ЭМД-д даатгуулагчдийн тоо	6321	719.9
5) Тэтгэвэр авагчдийн тоо: Үүнээс	30190	8197.1
6) Тэтгэмжийн даатгалын тэтгэмж авагчдын тоо	797	312.8
7) ҮОМШӨ-ний даатгалын тэтгэмж авагчдын тоо	501	176.5
8) Ажилгүйдлийн даатгалын тэтгэмж авагчдын тоо	131	171.1

Зураг- 10. Нийгмийн даатгалын зардлын төрөл, хувиар





## ЦАГДААГИЙН 1, 2, 3-Р ХЭЛТЭС

### Гэмт хэргийн гаралт

Оны эхний 01 сарын байдлаар цагдаагийн хэлтэст бүртгэгдсэн гэмт хэргийн тоо нийт 312 болсон бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 68 хэргээр буюу 27.87 хувиар өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 43.48 хувьтай байна.


Хүснэгт 11. Гэмт хэргийн тоо, хороогоор өмнөх онтой харьцуулснаар

Хороо	2014.01 сар	2015.01 сар	Өсөлт бууралт	Хороо	2014.01 сар	2015.01 сар	Өсөлт бууралт
<b>1</b>	13	11	-15.38	<b>18</b>	9	16	77.78
<b>2</b>	12	9	-25.00	<b>19</b>	12	21	75.00
<b>3</b>	4	7	75.00	<b>20</b>	5	18	2.6 дахин
<b>4</b>	10	8	-20.00	<b>21</b>	5	5	0.00
<b>5</b>	9	7	-22.22	<b>22</b>	9	15	66.67
<b>6</b>	9	9	0.00	<b>23</b>	10	7	-30.00
<b>7</b>	12	15	25.00	<b>24</b>	6	7	16.67
<b>8</b>	7	5	-28.57	<b>25</b>	6	7	16.67
<b>9</b>	5	7	40.00	<b>26</b>	11	14	27.27
<b>10</b>	6	11	83.33	<b>27</b>	7	8	14.29
<b>11</b>	5	7	40.00	<b>28</b>	2	6	2 дахин
<b>12</b>	8	14	75.00	<b>29</b>	15	15	0.00
<b>13</b>	2	6	2 дахин	<b>30</b>	7	4	-42.86
<b>14</b>	11	14	27.27	<b>31</b>	3	11	2.6 дахин
<b>15</b>	5	9	80.00	<b>32</b>	5	3	-40.00
<b>16</b>	2	8	3 дахин	-	10	-	-
<b>17</b>	2	8	3 дахин	<b>Дүн</b>	244	312	27.87

Гэмт хэргийн гаралтыг хороогоор харвал оны эхний нэг сарын байдлаар хамгийн их гэмт хэрэг гарсан хороо нь 19-р хороо бөгөөд 21 хэрэг бүртгэгдсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 75.00 хувиар өссөн үзүүлэлт харагдаж байна. 19-р хороонд гарсан нийт хэргийн 5 буюу 23.81 хувь нь хулгайн гэмт хэрэг байна. Харин хамгийн бага хэрэг бүртгэгдсэн 32-р хороо бөгөөд 3 хэрэг бүртгэгдсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 40.00 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд гарсан гэмт хэргийн гаралтыг төрлөөр нь харвал хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 15 буюу нийт гэмт хэргийн 4.81 хувь, дээрмийн гэмт хэрэг 17 буюу нийт гэмт хэргийн 5.45 хувь, хулгайн гэмт хэрэг 93 гарсан нь нийт гэмт хэргийн 29.81 хувийг тус тус эзэлж байна. Хулгайн гэмт хэрэг дотроос хамгийн их бүртгэгдсэн хороо нь 22-р хороо бөгөөд нийт хулгайн хэргийн 11 нь буюу 11.83 хувийг эзэлж байна. Нийт хулгайн хэргийн 86 нь буюу 92.47 хувийг өмчийн хулгайн хэрэг байна.

Зураг- 13. Хулгайн гэмт хэргийн хэргийн тоо, хороогоор /2015 оны 01 сарын байдлаар/



Хүснэгт 12. Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг, төрлөөр, хороогоор

	Хүнийг санаатай алах	Бусдыг амиа хорлоход хүргэх	ББМБУ	Хүчиндэх	Хулгай	Булаах	Дээрэмдэх	Залилан	Танхайрах	ТХХАБАЖЭ	Бусад	Бүгд дүн
1-р хороо	0	0	3	0	4	0	0	0	1	1	2	11
2-р хороо	0	1	3	0	3	0	1	0	1	0	0	9
3-р хороо	0	1	1	1	1	1	1	1	0	0	0	7
4-р хороо	0	1	2	0	0	0	0	1	1	1	2	8
5-р хороо	0	0	3	0	0	0	1	0	0	2	1	7
6-р хороо	0	1	1	0	1	0	0	2	1	0	3	9
7-р хороо	0	3	5	0	5	0	0	0	2	0	0	15
8-р хороо	0	1	2	0	2	0	0	0	0	0	0	5
9-р хороо	0	1	3	0	3	0	0	0	0	0	0	7
10-р хороо	0	0	5	0	2	0	1	0	0	2	1	11
11-р хороо	0	0	0	0	3	0	0	1	2	0	1	7
12-р хороо	0	0	2	0	3	0	3	1	2	1	2	14
13-р хороо	0	0	0	0	1	0	1	0	1	3	0	6
14-р хороо	0	1	2	0	2	0	1	4	2	1	1	14
15-р хороо	0	0	0	0	3	1	2	0	1	1	1	9
16-р хороо	0	0	2	0	3	0	1	0	1	1	0	8
17-р хороо	0	0	3	0	1	0	1	0	1	2	0	8
18-р хороо	0	0	7	0	4	0	1	3	0	1	0	16
19-р хороо	1	1	6	0	5	0	1	3	3	1	0	21
20-р хороо	0	0	1	0	8	1	0	1	0	2	5	18
21-р хороо	0	0	0	0	4	0	0	0	0	0	1	5
22-р хороо	0	1	3	0	11	0	0	0	0	0	0	15
23-р хороо	1	0	3	0	3	0	0	0	0	0	0	7
24-р хороо	0	0	2	0	1	0	0	0	1	3	0	7
25-р хороо	0	1	2	1	1	0	0	0	0	0	2	7
26-р хороо	0	1	5	0	5	0	1	1	0	0	1	14
27-р хороо	0	0	5	0	0	1	0	0	1	0	1	8
28-р хороо	0	0	3	0	2	0	0	0	0	0	1	6
29-р хороо	0	0	7	0	2	0	1	2	1	1	1	15
30-р хороо	0	0	3	0	1	0	0	0	0	0	0	4
31-р хороо	0	0	3	0	7	0	0	1	0	0	0	11
32-р хороо	0	1	0	0	2	0	0	0	0	0	0	3
Бүгд	2	15	87	2	93	4	17	21	22	23	26	312

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ